ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНГЭЭХ ЧАДВАР, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

(Мэдээлэл лавлагаа)

Д-р Г.Алтан-Оч, Ц. Элбэгзаяа

Судалсан байдал: Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол доорх эх сурвалж буюу цахим хуудасны мэдээллийг ашигласан болно. Үүнд:

1. “Absorptive capacity“, WikipediA (The Free Encyclopedia) http://en.wikipedia.org/wiki/Absorptive_capacity
2. H. Nguyen нар, “Foreign Direct Investment Absorptive Capacity Theory”, Eindhoven University of Technologies (TU/e), Netherlands, 2009 https://smartech.gatech.edu/bitstream/handle/1853/35267/1238510767_HN.pdf;jsessionid=D139491CF6F758308ED6D385CF328803.smart2?sequence=1
3. Beatrice Parkas, “Absorptive Capacities and the Impact of FDI on Economic Growth”, DIW Berlin, Germany, 2012 file://SSRN-id2038182.pdf
4. Соёмбо 2 баг, “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа”, Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо, 2011 file://Soyombo II bag - negdsen tailan - last version.pdf

Нэг. Ерөнхий ойлголт

Удирдахуйн шинжлэх ухаанд шингээх чадварыг “шинэ мэдээллийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх, түүнийг өөрийн болгох, улмаар ашиг олоход хэрэглэх аж ахуйн нэгжийн чадавх”[174] гэж анх 1990 онд тодорхойлсон байдаг. Түүнийг хувь хүн, бүлэг этгээд, байгууллага дээр, цаашилбал улсын хэмжээнд ч авч үзэж болно. Угтвар нөхцөл нь өмнөх мэдлэг (мэдлэгийн сан, мэдлэгийн урсгал) болон хэлхээ харилцаа[175] мөн. Судалгааны хүрээ нь аж ахуйн нэгж (ААН)-ийн инновацийн чадавх, тэмүүллийн түвшин, бүтэц зохион байгуулалтын суралцах байдлыг хамардаг. Иноватив (шинэ санаачлагатай) байхын тулд аливаа ААН өөрийнхөө шингээх чадварыг хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг.[1]

Шингээх чадварт хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл бол өмнөх мэдлэг болон олон талт үндэс суурь[176] юм. Ийм учраас байгууллагууд шингээх чадвараа хөгжүүлэхийн тулд эрдэм шинжилгээний ажлыг[177] гол загвараа болгодог. Мөн ААН-үүд *пост фактум*[178] үр дүнг (жишээлбэл, патент гэх мэт) хялбархан худалдаж авахын оронд эрдэм шинжилгээний ажил (ЭША)-д хөрөнгө оруулдаг шалтгааныг шингээх чадвар гэж үздэг. Дотоодын ЭША-ын баг нь тухайн ААН-ийн шингээх чадварыг нэмэгдүүлнэ. ААН ЭША-д хөрөнгө оруулах тусам гадны шинэ мэдээллийг бүрэн хүлээж авах чадавхтай болдог.[1]

Cohen, Levinthal нар олон талт байдал нь хувь хүнд “огт байгаагүй шинэ нийгэмлэг болон харилцаа холбоос” бий болгох боломж олгодог гэж үзсэн байдаг. Иймээс тэд янз бүрийн хүмүүсийг хамтарч ажиллуулах, юмс үзэгдлийг өөр өнцгөөс харах боломж олгохуйц олон талт баг авч ажиллуулахыг эрхэмлэдэг байв.[1]

Шингээх чадвар нь хуримтлагдах шинжтэй. Энэ нь байгууллагын хувьд, тогтмол байдалтай хөрөнгө оруулах нь нэг удаа бөөн хөрөнгө оруулахаас илүү дөхөмтэй гэсэн үг. Шингээх чадвараа хөгжүүлэх зорилгоор нэгэн үед гаргасан зүтгэл чармайлтыг дараагийн үед арвижуулахад амар байдаг.[1]

---

[174]Cohen and Levinthal (1990), “Absorptive capacity: A new perspective on learning and innovation”, Administrative Science Quarterly, Volume 35, Issue 1, pg. 128-152

[175]communication

[176]backround

[177]Research and Development

[178]Post factum

Cohen, Levinthal нар ЭША-д хөрөнгө оруулахыг маш ихээр анхаарч үзсэн бол олон судлаачид хожим нь шингээх чадварт нөлөөлдөг зарим өөр үзүүлэлтүүдийг нээн илрүүлж, улмаар 2002 онд байгууллагын шингээх чадвар хэмээх шинэ тодорхойлолт бий болгон үзэл санааг нь баяжуулан хөгжүүлсэн[179]. Zahra, George нар шингээх чадварыг "ААН мэдлэгийг олж авах, өөрийн болгох, хувиргах болон ашиглах замаар зохион байгуулалт, бүтцийн динамик чадавхтай болохуйц зохион байгуулалтын хэвшмэл ажил[180], процессийн нэгдэл" гэж шинээр тодорхойлсон. Мөн шингээх чадварыг дотор нь болзошгүй шингээх чадвар[181], хэрэгжүүлэх шингээх чадвар[182] гэж хуваан авч үзсэн байдаг.[1]

Болзошгүй шингээх чадвар. Zahra, George нарын үзсэнчлэн, болзошгүй шингээх чадвар нь хоёр элементээс бүрдэнэ. Эхнийх нь *мэдлэг олж авахтай* холбоотой, "өөрийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой гадны мэдлэгийг олж тогтоох, түүнийг олж авах чадавх"-ад хамаарна. Хоёрдахь нь мэдлэгийг *өөрийн болгох чадавхтай* холбоотой бөгөөд "гадны эх үүсвэрээс олж авсан мэдээллийг ойлгох, хөрвүүлэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх зорилгоор ААН-ийн авч хэрэгжүүлэх хэвшмэл ажил, процесс"-д хамаарна. Нэгтгэн дүгнэвэл, "болзошгүй шингээх чадвар нь ААН-ийг гадны мэдлэгийг олж авамтгай, өөрийн болгомтгой болгодог".[1]

Хэрэгжүүлэх шингээх чадвар. Хэрэгжүүлэх шингээх чадвар нь нэг талаас "байгаа мэдлэг болон шинээр олж авч, өөрийн болгосон мэдлэгийг хослуулах замаар хэвшмэл ажлуудаа боловсронгуй болгох, сайжруулах чадавх" буюу *хувиргах чадавхыг* илтгэдэг. Нөгөөтэйгүүр, хэрэгжүүлэх шингээх чадвар нь ААН-ийн *ашиглах чадавхыг* илтгэх бөгөөд үндсэндээ шинээр олж авсан мэдлэгийг үйлдвэрлэл, үйлчилгээндээ нэвтрүүлэх замаар санхүүгийн ашиг олох чадавх юм. Хэрэгжүүлэх шингээх чадвар нь хувиргах болон ашиглах чадавхын функц юм.[1]

Zahra, George нар шингээх чадварын элемент бүрд тохирсон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг санал болгосон байдаг. Үүнд:

- Мэдлэг олж авах чадавх (ЭША эрхэлсэн жил, ЭША-д оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ)
- Өөрийн болгох чадавх (ААН хоорондын патентийн ишлэлийн тоо, ААН-ийн эрдэм шинжилгээний нийтлэлийг бусад ААН-ийнхэд ишлэсэн тоо)
- Хувиргах чадавх (шинэ бүтээгдэхүүний санаа гаргасан тоо, эрдэм шинжилгээний шинэ төсөл санаачилсан тоо)
- Ашиглах чадавх (патентийн тоо, шинэ бүтээгдэхүүн танилцуулсан тоо, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мөчлөгийн урт)

Сэдэвтэй холбогдох бусад судалгааны чиглэлүүд. Шингээх чадвартай холбогдох эрдэм шинжилгээний ажлууд дараах сэдвүүдэд төвлөрч байна. Үүнд: эрдэм шинжилгээний ажил, мэдлэгийн удирдлага (менежмент), бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, хамтын ажиллагаа[183], нийгмийн баялаг[184], бэлтгэн нийлүүлэгчийн интеграци, хэрэглэгч (худалдан авагч/үйлчлүүлэгч)-ийн интеграци, байгууллага хоорондын нийлэмж[185] гэх мэт[1]

Өнөө үед онолын судалгаа нь байгууллагын суралцах чадвар, аж үйлдвэрийн эдийн засаг, ААН-ийн нөөцөд суурилсан үнэлгээ болон динамик чадавх[186] зэрэг чиглэлээр хөгжиж байна. Тухайн онол нь үндсэндээ боловсронгуй болсон бөгөөд шингээх чадвар гэдгийн дор динамик чадавхыг ойлгодог болжээ.[1]

[179]Shaker Zahra and Gerry George (2002), "Absorptive Capacity: A Review, Reconceptualization, and Extension", Academy of Management Review, Volume 27, Issue 2, pg. 185-203
[180]routines
[181] Potencial absorptive capacity
[182]Realized absorptive capacity
[183]External interactions
[184]Social capital
[185]Inter-organizational fit
[186]Capability

Шингээх чадвартай холбоотой хоёр концепци байдаг. Үүнд:

- Хүлээн авах чадвар[187]: Технологийн тухай мэддэг байх, түүнийг олж тогтоох, үр бүтээлтэй ашиглан давуу байдал олж авах нийтлэг чадамж[188]
- Шинэлэг (иноватив) хэвшмэл ажил: Инновацийн чармайлтад төвлөрөх бөгөөд найдвартай ажиллагааг хангахуйц, нэвтрүүлсэн хэвшмэл ажлууд[1]

Хөрөнгө оруулалтын шингээх чадвар нь 2 үе шаттай байдаг. Эхний үе шатыг хөрөнгө оруулалтын бөөний[189] хөрөнгийн үе гэх ба гадаадын хөрөнгө оруулалтын төслийг практикт хэрэгжүүлэхийг хэлнэ. Удаах үе шатанд хөрөнгө оруулалтын үр ашгийг эзэн улсын дадал чадвар[190] болгон хувиргадаг.[2]

Хоёр. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) гэж ерөнхийдөө нэг улсаас нөгөө рүү хөрөнгө, технологи, ноу-хау урсахыг хэлнэ. Олон улсын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтаас шууд өгөөж хүртдэг бол эзэн орон ямар ашиг хүртэх нь тодорхойгүй байдаг. Өнгөц харахад, хөрөнгө, боловсронгуй технологи, сайжруулсан удирдахуйн чадвар зэрэг ашиг тусыг тухайн улсад хүртээнэ. Гэвч *эдгээр ашиг тус нь автоматаар эзэн улсын үр ашиг*[191] *болж хувирдаггүй.* Энэхүү процесс нь эзэн улс хангалттай шингээх чадвартай байх нөхцөлийг шаарддаг. Хөгжиж буй олон улсууд ГШХО-ыг урин далладаг боловч ГШХО-аас ашиг шингээж авахын тулд анхан шатны нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой гэдгийг ойлгодоггүй. Nunnemkamp (2004) аливаа улс ГШХО-ыг ашиглахаас урьтаж эдийн засгийн хөгжлөө минимум түвшинд хүргэсэн байх шаардлагатай, эс бөгөөс ГШХО-аас их зүйл хүлээгээд нэмэргүй гэжээ.[2]

1990-ээд оноос хойш дэлхий даяар ГШХО-ын хэмжээ огцом өссөн. ГШХО-ын хэмжээ 1990 оны үеэс даруй 3 дахин нэмэгдсэн бол 2000 оны байдлаар, хувийн хөрөнгийн урсгалын 50%-иас илүүг хөгжиж буй улсуудад орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Эндээс ГШХО нь дэлхийн бөмбөрцгийг маш их хамарсан, хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих хүчтэй хөшүүрэг болж ач холбогдол нь улам бүр нэмэгдэж, даяаршлын нэгэн илэрхийлэл болсон нь харагдана.[3]

Гэвч хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтөд ГШХО-ын үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байна. Үүний шалтгааныг өмнөх үеийн судалгаануудад тухайн улсын шингээх чадвараас хамаардаг гэж үзсэн. Энэхүү тайлбарын үндэс нь, хөгжиж буй улс нь дэвшилт технологид хандсанаар өөрийнхөө хөдөлмөрийн нийт бүтээмж[192] (ХНБ)-ийг нэмэгдүүлнэ гэсэн ГШХО-ын үзэл санаанд (номлолд) оршино.[3]

ГШХО-аас аливаа эзэн улс ашиг хүртэхийн тулд хангалттай шингээх чадвартай байх ёстой. Шингээх чадвар нь **хүний баялгийн нөөц, дотоодын компаниудын шингээх чадвар, санхүүгийн систем, биет дэд бүтэц, ЭША-ын түвшин, технологийн болон байгууллын**[193] *хөгжлөөс* шууд хамаардаг.[2]

Эдийн засгийн өсөлтийг тодорхойлох хүчин зүйлүүд нь шингээх чадварыг тодорхойлдог үзүүлэлтүүдээс бүрдэх бөгөөд өмнөх судалгаануудад эдгээрийг **санхүүгийн зах зээлийн хөгжил, хүний баялгийн түвшин, худалдааны нээлттэй байдал, байгалийн баялаг элбэг байх, өрхийн орлогын түвшин, технологийн зааг** гэж тогтоосон байдаг.[3]

[187]Receptivity
[188]Ability
[189]disbursing
[190]Competence
[191]Spillover
[192]Total-factor Productivity
[193]institutional

ГШХО-ын үзүүлэх нөлөө тухайн улсын онцлог бүхий шингээх чадвараас хамаарна. Судалгаанаас үзэхэд, ГШХО нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлдөг бөгөөд хүний баялаг болон санхүүгийн тогтолцооны түвшнээс *мэдэгдэхүйц* хамаардаг. Гэхдээ тэрээр хөгжиж буй орнуудад өсөлтийн бусад үзүүлэлтүүдийг орлох бус, харин ч гүйцээн дүүргэж өгдөг.[3]

Санхүүгийн зах зээл сайн хөгжсөн улс оронд хөдөө аж ахуй буюу газрын тосны экспорт бага байсан ч оршин тогтнохын үндэс болсон нийгмийн хангалуун байдал[194] дээшлэхэд ГШХО оновчтой тохирдгийг тогтоосон. Судалгаанаас үзэхэд, хэрэв хүний баялгийн хөгжил доогуур ээзн улсад зөвхөн санхүүгийн зах зээл нь сайн хөгжсөн бол ГШХО эерэг үр дагавар үзүүлж байгаа нь ажиглагдсан. Мөн эрчимтэйгээр арилжаа эрхэлж буй газрын тосоор баян улсуудын эдийн засгийн өсөлтөд ГШХО бага нөлөөлдөг нь харагдсан.[3]

Өмнөх судалгаануудаас харахад, ГШХО нь зөвхөн боловсронгуй санхүүгийн зах зээл болон хүний баялаг харьцангуй дээд түвшинд хүрсэн нөхцөлд л эдийн засгийн өсөлтөд нөлөөлж үр ашгаа өгдөг нь тогтоогдсон. Мэдээж ГШХО-ын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг эхний шууд үр ашиг нь гадаадын хөрөнгө оруулагчаас орж ирэх шууд санхүүжилтийн хөрөнгө юм. Удаах үр ашиг нь ихэвчлэн баян улсаас ядуу улс руу шилжих технологи нэвтрэлтээс[195] бүрдэнэ. Romer (1990) нэг ажилтанд ногдох ДНБ[196] улс орнуудын хувьд асар их зааг ялгаатай байна гэдгийг анх удаа олж харсан (өөрөөр хэлбэл, технологи болон бүтээмжийн зааг буюу ХНБ). Үндэстэн дамнасан корпорациуд (ҮДК) дэлхийн ЭША-ын дийлэнхийг хийдгийн хувьд, тухайн хөгжиж буй улсад тэдгээрийн оршин байгаа нь технологи дамжуулалтыг[197] тэтгэдэг. Энэхүү процесс нь технологи дууриалгах[198]/зүгшрүүлэхээс[199] авахуулаад аж үйлдвэрүүдийг холбох гүүр болон өндөр бүтээмжийн шинжээр илэрдэг.[3]

Технологи нэвтрүүлэлт нэмэгдэх, бүтээмж дээшлэх, хөгжиж буй зах зээл рүү хандах, бизнесийн ноу-хау дамжуулах болон ажилтныг сургах зэргээр ГХШО нь тухайн эзэн улсын эдийн засгийн өсөлтөд зөвхөн эерэг нөлөө үзүүлдэг гэж үздэг нийтлэг зөн совин[200] оршдог. Үр дагавар нь хөгжиж буй улсууд ГШХО-ын хязгаарлалтыг хялбаршуулж, татварын урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх маягаар гадаадын хөрөнгийг урин даллаж байгаагаар илэрнэ. Гэвч ГШХО болон эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарлын чиглэл ямар байгаа буюу ГШХО эдийн засгийн өсөлтийг хангаж байгаа эсэх, эсвэл эсрэгээрээ юу гэдгийг одоогоор *тодорхойлох боломжгүй* байгааг туршлага харууллаа. Ихэнх тохиолдолд үгүй байна. Микро түвшний өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнээс харахад, ГШХО эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлэхгүй байгаа бол макро эдийн засгийн (улсын салбар дамнасан ГШХО-ын урсгалын хүрээний) судалгаанаас үзэхэд, ГШХО эзэн улс шингээх чадвартай нөхцөлд л өсөлтийг түргэсгэдэг. Өөрөөр хэлбэл, эдгээр судалгаанууд гадаадын технологийг нутагшуулах түвшин нь хөгжиж буй улсын шингээх чадвараас хамааралтай гэдгийг харуулж байна.[3]

Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD[201])-ын 2002 оны тайланд, ГШХО нь технологийн үр ашгийг өдөөж, хүний баялаг бүрэлдэн тогтоход дэмжлэг үзүүлж, олон улсын худалдааны интеграцийг хөхиүлэн дэмжиж, илүү өрсөлдөөнтэй бизнесийн орчин бий болохыг тэтгэж, байгууллагын цар хүрээг өргөжүүлэн тэлдэг хэмээн тусгажээ. Мөн ГШХО-аар дамжин буй технологи аль болох “цэвэр” байх тусам эзэн улсын байгаль орчин, нийгмийн байдалд сайнаар нөлөөлнө гэжээ.[2]

[194]welfare
[195]Technology diffusion
[196]Дотоодын нийт бүтээгдэхүүн
[197]Technology transfer
[198]imitation
[199]adoption
[200]Common intuition
[201]Organization for Economic Co-operation and Development

De Mello (1997) технологийн зааг хэдий чинээ их байвал ГШХО-аас эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө төдий хэмжээгээр бага байна гэж хэлсэн.[2]

Borensztein, De Gregorio болон Lee (1998) нарын үзсэнээр, аж үйлдвэрийн бүхий л салбарт шинэ технологийн үр шимийг түгээн дэлгэрүүлэх үүргийг мэргэжилтэй боловсон хүчин гүйцэтгэдэг. Эзэн улсын хүний баялгийн түвшин зөвхөн минимум түвшинд байхад л ГШХО нь эдийн засгийн өсөлтийг түргэсгэх чадвартай байдаг. Тэд ГХШО-ын нөлөөгөөр өсөлт бий болох нь хөрөнгийн хуримтлалаас биш харин технологи нэвтрэлтээс илүүтэй шалтгаалдаг гэж үзсэн.[3] Nunnemkamp (2004) тэмдэглэсэнчлэн, ҮДК-д өмнө нь бэлтгэгдсэн ажилтныг авч ажиллуулах нь дотоодын компаниудын хувьд үр дүнтэй.[2]

Blomstrom, Lipsey болон Zejan (1994) нар ГШХО-ын нөлөөгөөр эдийн засаг өсөх нь боловсролоос бус харин тухайн эзэн улсын өрхийн орлогын түвшнээс илүүтэй шалтгаална гэж үзсэн.[3]

ГШХО эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх бас нэгэн шалгуур үзүүлэлт бол Balusubramayam, Salisu болон Sapsford (1999) нарын үзэж байгаагаар худалдааны нээлттэй байдал юм.[3]

Дэлхийн 69 орны 1975-2000 оны хоорондох ГШХО-ын хэмжээ, эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч бусад хүчин зүйлүүдийг судалж үзэхэд, ДНБ-д эзлэх ГШХО-ын хэмжээ Сингапур улсад хамгийн өндөр бөгөөд Өмнөд Африкаас даруй 47 дахин их байна. Дэлхийн дундаж 1.76% байна. Дээрх хугацаанд хамгийн өндөр өсөлтийг Өмнөд Солонгос үзүүлжээ (6.081%). Удаах байрыг Хятад 5.835%-иар эзлэх бөгөөд энэ улсын ДНБ-ий хэмжээ хугацааны эхэнд сүүлээсээ 2 дугаарт бичигдэж байв.[3]

Дээрх судалгаанд шингээх чадварыг эс тооцон үзвэл, эдийн засгийн өсөлтөд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлүүд нь гарааны үеийн өрхийн орлогын түвшин, хүний баялаг, хөрөнгө оруулалтын индекс (ДНБ-нд эзлэх нийт хөрөнгө оруулалтын хувь хэмжээ) байна. Эдгээр үзүүлэлтийн регрессийн коэффициент эерэг бөгөөд 5%-ийн түвшинд эрс мэдэгдэхүйц илэрч байна. ГШХО (регрессийн коэф: 0.224) эерэг, 10%-ийн түвшинд мэдрэгдэх бөгөөд ДНБ-ий өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг нь ажиглагдлаа. Санхүүгийн хөгжлийн үзүүлэлтийн коэффициент (хувийн зээл[202]) эерэг бөгөөд 10%-ийн түвшинд мэдэгдэхүйц статистиктай байна. Энэ нь юу вэ гэвэл, хувийн зээлийн хувь хэмжээ 1% өсөхөд ДНБ-ий өсөлт 0.05% байна гэсэн үг.[3]

Харин шингээх чадварыг хамтруулан тооцож үзвэл, ГШХО-санхүүгийн хөгжлийн индекс гэсэн хослол 5%-ийн мэдэгдэхүйц түвшинд 2 дахинаас илүүтэйгээр өсөлтөд нөлөөлдөг болох нь харагдлаа. Эндээс ГШХО-аар эдийн засгийн өсөлтийг хангахад санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин шийдвэрлэх үүрэгтэй гэдэг дүгнэлт хийж болохоор байна. ГШХО-Хөдөө аж ахуй гэсэн хослолын хувьд, харилцан хамаарлын коэффициент сөрөг бөгөөд үл мэдэгдэхүйц байна. Эндээс дүгнэхэд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нь ГШХО-аар дамжин эдийн өсөлтөд бага нөлөө үзүүлдэг. Газрын тосны экспорт, хүний баялгийн хувьд ГШХО-ын итгэлцүүр эерэг боловч үл мэдэгдэхүйц байгаа бол худалдааны нээлттэй байдлын хувьд харин ч сөрөг (үл мэдэгдэхүйц) нөлөөтэй байна.[3]

Цаашлаад өрхийн орлогын үзүүлэлтийг судалж үзэхэд, хөгжингүй болон өрхийн орлого ихтэй OECD-ын орнуудад ГШХО-ын итгэлцүүр сөрөг бөгөөд үл мэдэгдэхүйц байна. Гэхдээ хүний баялаг болон худалдааны нээлттэй байдлаар, бүр цаашлаад хувийн зээл болон хөдөө аж ахуйгаар ч шингээх чадварыг төлөөлүүлэн авч үзвэл, ГШХО-ын итгэлцүүр мэдэгдэхүйц болж байгаа нь харагдлаа. Түүнчлэн, ГХШО-сургалт гэсэн хослол 5%-ийн

[202]Private credit

түвшинд мэдрэгдэж байна. Энэ нь хүний баялгийн оюуны өндөр чадавх нь ГШХО-аар дамжин эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлдөг гэж өмнөх судалгаануудад дурдсан байдгийг нотолж байна.[3]

Байгалийн баялаг арвин байх нь эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүйг судалгаа харууллаа. Эрчимтэйгээр олборлож буй газрын тосоор баян улсуудын өсөлт нь ҮДК-иудын тэдгээр орнуудад оруулах хөрөнгө оруулалтыг бууруулахад нөлөөлж байна.[3]

Ингээд дээрх гадаадын шууд хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаанууд дээр үндэслэн доорх байдлаар дүгнэх буюу анхаарал татах асуудлуудыг нэгтгэн тоймлож болохоор байна. Үүнд:

1. Улсын эдийн засгийн өсөлтийг тодорхойлох хүчин зүйлүүд нь шингээх чадварыг тодорхойлох үзүүлэлтүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь санхүүгийн зах зээлийн тогтолцоо, хүний нөөцийн баялгийн оюуны чадавх, байгууллын тогтолцоо, өрхийн орлого, худалдааны нээлттэй байдал, биет дэд бүтэц, эрдэм шинжилгээний ажил буюу технологийн заагийн түвшин болон байгалийн нөөцийн баян байдал болно.
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас эерэг үр ашиг хүртэхэд хамгийн үр дүнтэй хүчин зүйл буюу амин чухал үүрэгтэй шалгуур үзүүлэлт бол хамгийн бага түвшний хүний нөөцийн баялаг болон сайн хөгжсөн санхүүгийн зах зээлийн тогтолцоо юм.
3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгосон орнуудад байгалийн нөөцөөр хомс буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ бага ч гэсэн санхүүгийн зах зээлийн тогтолцоо нь сайн хөгжсөн улсууд багтаж байна.
4. Сайн хөгжсөн санхүүгийн зах зээлийн нөхцөл нь хүний баялгийн босго түвшинтэй харьцуулахад илүү давамгай ач холбогдолтой.

Гурав. Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар[4]

Сүүлийн жилүүдэд манай улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулалтын орчин нөхцөл сайжирч, эдийн засгийн бодит салбарууд болон дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хурдацтайгаар нэмэгдсээр байна. Манай улсад 90 орчим орны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийж, 40 орчим улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талын хэлэлцээр байгуулжээ.

Дэлхийн зах зээл дэх газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, түүхий эдийн үнэ тариф огцом өсч, үүнтэй уялдан “Оюу толгой”, “Таван толгой” зэрэг ашигт малтмалын баялаг, томоохон орд, газруудын ашиглалттай холбоотойгоор манай улсын уул уурхайн салбарт ихээхэн хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөл бүрдээд байна. Хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар яригдах болж тухайн нэг оронд оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалт ашигтай байх эсэх нь тухайн орны хөрөнгө оруулалтын шингээх чадвараас ихээхэн хамаардаг болохыг судлаачид тогтоосон байдаг. Манайд гадаадын хөрөнгө оруулалт ихээр орж ирж байгаа хэдий ч үр дүн нь хангалтгүй байх тохиолдол байсаар байна. Энэ нь шингээх чадвар муутайн шинж гэж дүгнэсэн байдаг.

2007 онд зохион байгуулагдсан Монголд хөрөнгө оруулагчдын техникийн уулзалтын үеэр 2015 он хүртэл хугацаанд Монголын үндэсний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд 10 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шингээх чадвар бий гэж дүгнэсэн байдаг.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар манай улсад хийгдсэн судалгааны ажлуудаас эдийн засгийн ухааны доктор, профессор, академич Т.Доржийн 2008 онд хийгдсэн “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар”, мөн академич Т.Доржоор удирдуулсан оюутны дипломын ажлууд, 2011 онд Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооноос ойрын жилүүдэд уул уурхай болон дэд бүтцийн салбарт олон төслүүд хэрэгжихээр байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, манай улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар нарийвчилсан тооцоо судалгаа хийх зорилгоор “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа”-г хийсэн байна. Уг судалгаанд мөн эдийн засгийн ухааны доктор, профессор, академич Т.Дорж зөвлөхөөр ажилласан байна.

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар хийгдсэн анхны бодлогын судалгаа гэж хэлж болох “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа” нь өргөн хүрээг хамарсан, гадны эрдэмтэдийн дэвшүүлсэн онол, практик, аргачлал, тооцоо судалгаа, санал зөвлөмжийг нэг бүрчлэн тусгасан томоохон судалгааны ажил юм.

Уг судалгааны ажилд дотоодын болон гадаадын шууд хөрөнгө оруулалт манай улсад эрчимтэй өссөөр байгаа хэдий ч одоо болтол Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар тодорхой судалгаа хийгдээгүй байгааг онцолсон байна. Энэхүү судалгааг хийснээр манай улс цаашдаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөртөө татахад үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой юу эсвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахаасаа өмнө шингээх чадвартай болох хэрэгтэй юу гэдгийг зохистой шийдвэрлэх боломжтой болно хэмээн үзжээ.

2008-2012 оны байдлаар манай улсын уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтмол нэмэгдэж, 2010 онд ГШХО-ын 80 хувьд хүрсэн тооцоо байна. Тус судалгаанд хөрөнгө оруулалтын шингээх чадварын тухай ойлголт, онол, практик, хэрэглэгдэж болох болон ихэвчлэн хэрэглэдэг салбарууд, тодорхойлогч хүчин зүйлс буюу шингээх чадварт нөлөөлдөг хүчин зүйлсийг эрдэмтэд, судлаачид янз янзаар тодорхойлж, олон сонирхол татахуйц судалгааны үр дүн гарсан талаар дэлгэрэнгүй дурдсан байна.

Ихэнх судалгааны ажлуудад гадаадын хөрөнгө оруулалт ашигтай байх эсэх нь тухайн орны хөрөнгө оруулалтын шингээх чадвараас ихээхэн хамаардаг болохыг тогтоосон байна. Хувь хүмүүс шингээх чадвараа дээшлүүлж чадвал энэ нь байгууллагын шингээх чадварыг өсгөнө, байгууллагууд шингээх чадвараа дээшлүүлж чадвал улс орны шингээх чадвар өснө гэсэн хөрөнгө оруулалтын шингээх чадварын үндсэн санаад тулгуурлан Сигне Крогстрап, Линда Матаар нар:

1. Технологийн ялгаа
2. Ажиллах хүчний боловсролын түвшин
3. Санхүүгийн хөгжил
4. Институцийн хөгжил гэсэн хүчин зүйлүүдийг ашиглан тухайн нэг улс орны хөрөнгө оруулалтын шингээх чадварыг тодорхойлох боломжтой гэж нотолсон байдаг.

Дээр дурдсан 4 хүчин зүйлийн дагуу Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар хэр байгаа, шингээх чадварт нөлөөлөх техник технологийн нөлөө, загвар, тооцоолол, ажиллах хүчний нөлөөлөл, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх, санхүүгийн системийн нөлөөлөл ба эдийн засгийн халалтын судалгаа, мөн хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх институцийн хөгжлийн нөлөөллийг эдийн засгийн судалгаа, шинжилгээний олон аргаар тооцоолон судалж, үнэлэлт дүгнэлт өгсөнөөс тоймлон авч үзвэл:

1. Техник, технологийн түвшин хөрөнгө оруулалтын шингээх чадварт хэрхэн нөлөөлж байгаа талаар:

Манай улсын эдийн засагт ХАА, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Энэ нь эдийн засагт аж үйлдвэрийн салбар тэргүүлж буй мэт дүр зургийг харагдуулж байгаа боловч мэдлэг шингэсэн, эцсийн үйлдвэрлэл маш бага харин эрдэс түүхий эдийн олборлолтод суурилсан, уул уурхайн салбарын хөгжил түлхүү болж, уг салбарын цөөн нэр төрлийн бараа, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнээс манай эдийн засаг ихээхэн хамааралтай байна.

ГШХО-ын улс орны хөгжилд үзүүлэх нөлөөллийг технологийн зөрүүний индексийн арга (Ли болон Лю, 2005), бүтээгдэхүүний технологийн агууламжид үндэслэх арга (Эдвардо Бронгстейн, 1996), бүтээмжид үндэслэсэн арга (Алмас Хэшимати 2010)-ыг ашиглан тодорхойлдог. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч байгаа орны техник технологийн хөгжил хэдий чинээ бага байна, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тус улсын өсөлтөд үзүүлэх нөлөө төдий чинээ бага байдаг байна.

Технологийн зөрүүний индексийн аргаар босго оноог 12.6 гэж тодорхойлсон байдаг бөгөөд технологийн зөрүүний индекс 12.6-аас бага байвал тухайн оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт эерэгээр нөлөөлж байна гэсэн үг юм. Манай орны хувьд энэ үзүүлэлт нь 1990-2010 онуудад технологийн зөрүүний индекс 12.6-аас дээгүүр утгатай байгаа нь тухайн хугацаанд технологийн түвшнийхээ хувьд ГШХО-ын үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй гэсэн дүгнэлтийг өгчээ.

Монгол Улсын технологийн зөрүүний индекс өнгөрсөн 20 жилийн хугацаанд тогтворгүй байсан. Тиймээс манай улсын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалаас үр ашиг олохын тулд технологийн дэвшил хийх шаардлагатай гэж үзсэн байна. Мөн уг судалгаанд Монгол Улс одоогоор судлагдаж, олборлох, ашиглах үйл ажиллагаа эрчимжиж байгаа эрдэс баялгийн төрлөөс хамааруулан технологийн зөрүүний индекс багатай улсаас хөрөнгө оруулалт авснаар хөрөнгө оруулалтын шингээх чадвараа нэмэгдүүлэх боломжтой боловч энэ нь урт хугацаандаа үр ашигтай байж чадахгүй гэж үзжээ.

Манай улсын экспортын бүтээгдэхүүний технологийн агууламжийг шинжлэхэд технологийн агууламжгүй бүтээгдэхүүн 1994 онд нийт экспортын 74 хувийг эзэлж байсан бол 2004 онд 43 хувь хүртэл буурсан нь экспортын хувьд гарсан ахиц юм. Гэвч 2005-2010 онд нийт экспортод эзлэх технологийн агууламжгүй бүтээгдэхүүний хувь 44.66-аас 83.22 хувь хүртэл өсчээ. Нам, дундаж доор, дундаж, өндөр технологит бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь 1994-2004 онд харьцангуй тогтвортой байсан боловч 2005 оноос тасралтгүй буурсан байна.

Япон, АНУ, Герман, БНСУ зэрэг орны хувьд экспортын бүтээгдэхүүнд нам технологит бүтээгдэхүүн 10-20 хувь, дундаж өндөр технологит бүтээгдэхүүн 30-40 хувь, өндөр технологит бүтээгдэхүүн 20-40 хувийг эзэлж байдаг бол манай улсын хувьд нам технологит бүтээгдэхүүн 83.22 хувийг эзэлж, өндөр технологит бүтээгдэхүүний экспорт бараг байхгүй байна.

Бүтээгдэхүүний технологийн агууламжийн аргаар шинжлэн үзэхэд манай улс технологийн хоцрогдолд орсон гэж дүгнэжээ. Хэрвээ дундаж доод түвшнээс дээш технологийн агууламж бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарч технологийн бодлого хөтөлбөр хэрэгжүүлбэл хөрөнгө оруулалтын хэмжээ болон үйлдвэрлэлийн хэмжээг эрс нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн.

Манай улсын ДНБ-ий 60 орчим хувийг 5 дэд салбар үйлдвэрлэж, экспортын орлогын 70-аас дээш хувийг 5 нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж байгаа бөгөөд ноолуураас бусад нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүн байна. Үүнээс манай улсын эдийн засгийн бүтцийг хөдөө аж ахуй, уул уурхайн олборлох салбарын бүтээгдэхүүн зонхилсон өрөөсгөл бүтэцтэй хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улсын экспортын бүтцийн 80-аас дээш хувийг технологийн багтаамжгүй бүтээгдэхүүн, үлдсэн дийлэнх хэсгийг нам, дунд технологи шингэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ нь нийт экспортын 80 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байгаатай холбоотой. Эндээс манай улс технологийн агууламжгүй, нэмүү өртөг шингээгүй бүтээгдэхүүнийг голлон экспортолж байна.

Өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн урт хугацааны өсөлтөд нөлөөлөх технологийн нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг байхад манай улсын хувьд судалгаа ба хөгжилд оруулсан зардлын нийт төсөвт эзлэх хувь нэмэгдэхгүй байна.

Аж үйлдвэр, дэд бүтэц, технологийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг ОУЗЗ дээр гаргахын тулд тэргүүлэх салбарын технологийн хөгжлийн зураглалыг хийдэг тогтолцоотой болох, үндэсний технологийн хөгжлийн түвшний үнэлгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тогтмол хийдэг болох, манай орны хувьд технологийн хоцрогдлыг багасгах, үндэсний тэргүүлэх чиглэлийн технологиудыг дотооддоо хөгжүүлж, шаардлагатай технологийг гадаадын орнуудаас авч нутагшуулах, ирээдүйн технологийг бий болгохын тулд одооноос шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

2. Хөрөнгө оруулалтын шингээх чадварт ажиллах хүчний чадавх нөлөөлөх нь:

1993 онд батлагдсан гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд “Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуй нэгж байгуулах, эсхүл Монголын ААН-тэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ”[203] гэж тодорхойлжээ. Энэхүү хуульчилсан тодорхойлолтоос үзвэл хөрөнгө оруулалт нь эд хөрөнгийг бий болгохоос гадна оюуны үнэт зүйлсийг тодруулбал хүний оюунлаг хүчин зүйлийг багтаасан ойлголт учраас хүний хүчин зүйл, хүний хөгжил, ажиллах хүчний боловсролын түвшний хөрөнгө оруулалтыг шингээх чадварт үзүүлэх нөлөөллийг судлах энэ талын тооцоог бодитой хийх нь өндөр үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг бий болгоно.

Онолын үүднээс үзвэл ГШХО орж ирэх нь эдийн засгийн өсөлтөд эерэг шууд нөлөөтэй бөгөөд эдийн засгийн хөгжилд орчин үеийн шинэ техник, технологи, хүмүүсийн ерөнхий мэдээлэл, мэдлэг, чадвар дээшлэх, ажлын байр бий болох (өрхийн орлого нэмэгдэх), дэд бүтцийн орчин сайжрах, татварын орлого өсөх зэрэг хөгжлийн үзүүлэлтээр дамжин дам нөлөөг үзүүлдэг. Хөрөнгө оруулалтын дээрх эерэг үр дүн бий болохын хэрээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх бөгөөд үүнтэй уялдан санхүүгийн зах зээл улам бүр тогтвортой болно.

Гадаадад боловсрол эзэмшсэн мэргэжилтний тоо хэдий чинээ их байвал төдий чинээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын эерэг нөлөө өндөр байна гэж үздэг. Ажиллах хүчний боловсролын түвшний хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзсэн судалгааг хийхэд ажиллах хүчний чанарын түвшинтэй заавал холбох хэрэгтэй болдог. Ажиллах хүчин бол хүн аливаа нэг хэрэгцээний өртгийг бий болгох явцад ашиглаж байгаа оюуны болоод биеийн хүчний чадвар юм.

[203]“Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” УБ 1993. 2 дахь тал.

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр олон улсын хөрөнгө оруулалттай, ажилчин хүчний хөдөлмөрийн үнэлэмж өндөр хар зам тавих, барилга байгууламж барих, тохижилт хийх, тоног төхөөрөмж угсрах зэрэгт яагаад Монгол ажилчид ажиллахгүй гадаадын хятад ажилчид голлон ажиллаад байгаагийн шалтгаан нь хөдөлмөрийн нийлүүлэлтийн чанарын түвшин, ажиллах хүчний чанар хувийн хэвшлийн нөхцөлд гологдож байгаатай холбоотойг Монголын хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэсэн байна.

Иймээс ажиллах хүчний чанарыг өндөржүүлэхэд шууд хөрөнгө оруулалт нь мэргэжлийн өндөр түвшинг шаардах талаасаа ч, ерөөсөө боловсрол эзэмшээгүй байсан ч шууд хөрөнгө оруулалт нь ажиллах хүчний чанарыг өндөржүүлдэг гэж үздэг.

Боренсзтай, Корковик, Ливэйжи, Эйлфейро нарын онолын үүднээс авч үзсэн ч ажиллах хүчний чанар өндөржиж бүтээмж өсч, орлогыг илүү ихээр бий болгож, ажиллах хүчний ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлдэг болохыг тодорхойлсон байна. Хамгийн гол нь ШХО нь мэргэжил, мэргэшил олгох цаг хугацааг хэмнэдэг гэж үзжээ.

Ажиллах хүчний чанарын өсөлт нь ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлэх төдийгүй, бүтээмжийг өсгөх, олон улсын зах зээлээс шууд хөрөнгө оруулалтыг илүү олох, хүмүүс эрх чөлөөгөө эдлэх гол хүчин зүйл болдог байна.

Манай улсын ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувийг сүүлийн 10 жилээр авч үзвэл эхний 8 жилд дунджаар 20 орчим хувь байснаа 2009-2010 онд 24 хувь болж өссөн байна. Энэ үзүүлэлтийг дэлхийн улс орнуудын хандлагатай харьцуулж үзвэл ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувь харьцангуй доогуур байгаа нь ажиллагчдын дотор хувираа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэгчдийн эзлэх хувийн жин өндөр байгаатай холбоотой байж болох юм. Хэрэв Монгол Улсад нийт ажиллагчдын 50,0–аас дээш хувийг эзэлж байгаа хувираа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэгчдийн хөдөлмөрийн орлогыг оруулан тооцвол ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувийн жин дэлхийн түвшинд ойртох магадлалтай юм. Тиймээс малчид, хувираа хөдөлмөр эрхлэгчдийг аж ахуйн зохион байгуулалтад оруулах нь бүтээмж болон цалин хөлсний аль алийг нь нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

Манай улсын хувьд хөдөлмөрийн бүтээмж болон дундаж цалингийн өөрчлөлтийн хооронд эерэг хамааралтай байгаа бөгөөд хөдөлмөрийн бүтээмж буурахад цалин хөлс буурч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхэд дундаж цалин өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь цалин хөлсийг нэмэгдүүлэх хүчин зүйл гэдгийг илэрхийлж байна. Ажиллах хүчний зардал нь зөвхөн цалингаар хязгаарлагдахгүй, ажиллагсдын шагнал, урамшуулал, хоол, унааны зардал нийт зардалд тооцогдох ёстой. Мөн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу ажиллагчид цалин орлогоосоо нийтдээ 29 хувийн таван төрлийн татвар, шимтгэл төлдөг.

Монгол Улсад эдийн засгийн өсөлт нэмэгдэх хирээр нэрлэсэн дундаж цалин өсч байгаа ч инфляцийн түвшнээс хамааран бодит цалингийн өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, ажиллагчдын дундаж цалин 2005 онд 9 хувь, 2006 онд 26 хувь, 2007 онд 35 хувь, 2008 онд 58 хувиар тус тус нэмэгдсэн боловч түүний бодит өсөлт 2005 онд -0.8 хувь, 2006 онд 20, 2007 онд 17.7, 2008 онд 36.4, 2009 онд 5.4 хувь, 2010 онд 0.6 хувь байна. Энэхүү бодит цалингийн өсөлтөд тухайн жилийн инфляцийн түвшин нөлөөлж байгаа бөгөөд инфляцийн түвшин дундаж цалингийн өсөлтөд ойртох тутам ажилчдын цалингийн бодит өсөлт багасч, дундаж цалингийн өсөлтөөс инфляцийн түвшин бага байхын хирээр дундаж цалингийн бодит өсөлт харьцангуй өндөр болж байна. Үүнээс үзвэл цалин хөлсний өсөлт, түүний ажиллагчдын амьжиргаанд үзүүлэх нөлөө макро эдийн засгийн тогтвортой байдлаас ихээхэн хамааралтай байна.

Судалгаанаас харахад Монгол Улсын хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь ажиллах хүчний нөөц боломжийг өндөр түвшинд ашиглах, түүнд хүрэх оновчтой арга зам, гарцыг тодорхойлох ёстой гэж үзээд оновчтой гарц нь ажиллах хүчний хөрөнгө оруулалтыг шингээх чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай зардлын прогнозыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан тооцох явдал гэж үзсэн байна. Ингэснээр бүх хүмүүст таатай, бүтээмж өндөртэй, зохистой хөдөлмөрийг бий болгох, олон улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн бодлогод нийцэж зохицох болно. Хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээлийн ийм оновчтой бодлогод хүрэх зорилтын үүднээс Монгол Улсын хүн ам, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хүчний ашиглалттай уялдсан 2012-2021 оны хөгжлийн стратегид үндэслэсэн Монгол Улсын хөрөнгө оруулалтыг шингээх ажиллах хүчний чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай зардлын 2012-2021 оны прогнозыг эдийн засаг, математикийн аргаар тооцож дараах санал дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт нь боловсрол олгох хугацааг хэмнэдэг учир боловсролд зориулсан зардалтай уялдуулж байх
- ГШХО-ыг тухайн орны хүн капиталын хөгжлийн түвшинг хамт авч үзсэн нөхцөлд л эдийн засгийн өсөлтөд бусад капиталын бүрдлийн хэлбэрүүдээс илүү үр ашиг өгдөг байна.
- Өндөр хөгжилтэй орнуудад боловсрол эзэмшсэн мэргэжилтний тоо хэдий чинээ их байвал төдийн чинээ гадаадын хөрөнгө оруулалтын эерэг нөлөө өндөр байна гэдгийг бодолцон хөрөнгө оруулалтад тусгах, инвестиц хүнд зориулсан хөрөнгө оруулалтыг тооцдог байх
- Эрчимтэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах хөдөлгөгч хүч болдог тул шууд хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийг дэмжихэд түлхүү хуваарилах шаардлагатай байна.

3. Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх санхүүгийн системийн нөлөөлөл

Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт сүүлийн 10-аад жилийн хугацаанд харьцангуй тогтвортой өсч, сүүлийн жилүүдэд ДНБ-ий 30-40 хувьтай тэнцэх түвшинд хэлбэлзэж байна. Нийт хөрөнгө оруулалтад дотоодын хөрөнгө оруулалт 40 хувийг, гадаадын хөрөнгө оруулалт 60 хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын 50-55 орчим хувийг тоног төхөөрөмж, 25-30 хувийг барилга угсралт, 15-20 хувийг бусад зүйлд зарцуулж байна.

Дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байна. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлын хэмжээ 2010 онд 664,3 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 38 хувиар өсч, харин 2011 онд хөрөнгийн зардлын хэмжээ өмнөх онтой нь харьцуулахад бага зэрэг буурсан буюу 627,7 тэрбум төгрөгөөр батлагджээ. Зарим судалгаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч буй орны санхүүгийн зах зээлийн хөгжил тодорхой хөгжлийн түвшинд хүрсэн тохиолдолд улс орны хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг гэж баталсан байдаг.

Санхүүгийн тогтвортой байдал гэх ойлголт нь өргөн хүрээг хамардаг бөгөөд /Олон улсын валютын сан/ ОУВС болон улс орнуудын хувьд тэдгээрийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын орчин, банк санхүүгийн зах зээл, үнэт цаасны зах зээл болон бусад салбаруудыг төлөөлүүлэн авч үздэг. Аливаа улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь тухайн улс орны хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг байдаг. Улс орон болгон өөрийн онцлогоос хамааралтайгаар санхүүгийн тогтвортой байдлыг авч үздэг.

Манай орны хувьд санхүүгийн тогтвортой байдлыг эдийн засгийн орчин, олон улсын эдийн засаг үнийн орчин, хөрш орнуудын эдийн засгийн байдал, санхүүгийн салбарыг төлөөлүүлэн авах (манай орны хувьд санхүүгийн зах зээлийн 95.3 хувийг банкны

салбар эзэлдэг) боломжтой. ОУВС-аас санхүүгийн системийн тогтвортой байдал, түүнийг хүчирхэгжүүлж хяналт тавих, үнэлгээ хийхэд туслах зорилгоор санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцдог болсон. Өнгөрсөн үеүдэд гарч байсан олон улсын банк, санхүү, эдийн засгийн хямралууд нь санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-аас тооцоолох шаардлагыг бий болгосон бөгөөд гишүүн орнуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн жагсаалт болон тооцоолох аргачлалыг боловсруулан гаргасан байдаг. Үүний үр дүнд санхүүгийн тогтвортой байдлын 40 үзүүлэлтийг ОУВС-ийн удирдах зөвлөлд танилцуулан батлуулсан байдаг. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь тухайн улс орны санхүүгийн салбарын дүр зургийг харуулах бөгөөд олон улсад мөрддөг тул улс орнуудаар харьцуулалт хийхэд тохиромжтой гэж үздэг.

Одоогийн байдлаар, манай улсын банкны салбарт 14 банк нийт 1,272 салбар нэгж, 11,760 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Банкуудын нийт харилцагчдын тоо 2011 оны 8 дугаар сарын байдлаар 6.1 сая болж өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 3.2 саяар өссөн байна. Мөн нийт хадгаламж эзэмшигчид 1.1 дахин буюу 200 мянга, зээлдэгчид 90 мянгаар буюу 18.2 хувиар өссөн байна. 2012 оны жилиин эцсиин байдлаар арилжааны банкуудын ниит активын хэмжээ 10.9 триллион, үүнии 92 хувь хөшүүрэг эзлэж байна. Активын хэмжээ сүүлиин гурван жилиин хугацаанд 1.85 дахин өссөн хэдии ч хувь нийлүүлсэн хөрөнгиин өсөлт нь хөшүүргиин өсөлтииг гүицэхгүйгээс шалтгаалан эрсдэл даах чадвар буурч байна. 2000 оноос хоиш авч үзвэл дунджаар 12 хувь баигаа ба 2012 оны жилиин байдлаар 8,3 хувь байгаа нь дундаж утгаас доогуур буюу эрсдэл даах чадвар бага байна хэмээн дүгнэсэн байна.

Манай улсын 6 банк гадаадын хөрөнгө оруулалттай буюу эзэмшилд байгаа бөгөөд энэ нь нийт системийн 43%-г эзэлж байна. Өөрөөр хэлбэл Монголын санхүүгийн системд гадаадын хөрөнгө оруулалт маш их хэмжээгээр нэвтэрсэн нь харагдаж байна. Монголбанкны явуулж буй бодлого нь санхүүгийн болоод эзэмшлийн хувьд эрүүл тогтвортой байлгах үүднээс арилжааны банкуудад тавьж буй хяналт шалгалтаа чангатгаж байна.

Манай орны зээлдэх зэрэглэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Фич, Мүүдиз, Стандарт энд Пүэрс байгууллагууд "B+"[204] хэмээн тогтоосон байна.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх санхүүгийн системийн нөлөөллийн судалгаанаас дараах хэд хэдэн дүгнэлтийг хийсэн байна. Үүнд: Засгийн газрын хэрэгжүүлж буй Төсвийн бодлого нь макро эдийн засгийн суурь хөгжил, иргэдийн амьжиргааны баталгаат байдал зэрэгт түлхүү анхаарч байна. Нөгөө талдаа эдгээр бодлого нь хэт их үрэлгэн нүсэр бүтцээр явж байгаа нь эргээд эдийн засагтаа сөрөг хамаарлыг авчрах магадлалтай. Ялангуяа хөгжиж буй орны хувьд үнийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой байдал нь хамгаас чухал бөгөөд үүний төлөө мөнгөний болон төсвийн бодлого уялдаж байх ёстой байдаг. Мөн Монгол Улсын эдийн засагт мөнгөний бодлогын арга хэрэгсэлд гарах өөрчлөлт 4-8 улирлын дараа инфляцид хамгийн хүчтэй нөлөөлдөг ба мөнгөний бодлогын харьцангуй удаан үйлчлэл нь төсвийн идэвхтэй, хариуцлагатай бодлого явуулахыг шаардсан баримт хэмээн ойлгож болно. Өөрөөр хэлбэл, эрдэс баялгаас хараат байж тогтвортой мөчлөг сөрсөн, хариуцлагатай төсвийн тогтолцоотой байх хэрэгтэй гэсэн санаанууды гаргасан байна.

Тус судалгаанд уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, түүнийг дагасан их хэмжээний мөнгөн урсгалын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт огцом нэмэгдэж улмаар мөнгөний зөрүүг халааж байгаа ба төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр нийт эрэлтийг урамшуулж иргэдийн хэрэглээгээр дамжин эдийн засаг халж байна гэж үзсэн байна. Эдийн засаг халахын хэрээр түүнийг мөнгөний нийлүүлэлт өмч буй нь гэнэтийн уналтыг бий болгох магадлал

[204]Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 5 дахь илтгэл, 2013 он.

өндөр байдгийг бусад улсуудын жишээнээс харж болох бөгөөд уул уурхайн олборлолт дагасан эрэлтийн илүүдэл бүх салбарт шингэж нийт эрэлтийг дэвэргэн дахин хямралын байдлыг давтах нөхцөл байдал бүрдээд байгааг онцолсон байна. Арилжаааны банкуудын зээл олголтын байдлаар ялган үзвэл иргэдийн хэрэглээний зээлийн хэмжээ огцом ихээр нэмэгдэж буй нь иргэдийн эрэлтийг улам ихээр урамшуулж халалт нэмэгдэхэд үлэмж нөлөөтэй байна.

Эндээс улсын төсөв түүний урсгалын зардлын өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн халалт бий болж байна гэж үзэх үндэслэлтэй бөгөөд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа нь манайх шиг түүхий эдийн арвин баялаг нөөцтэй орны хувьд эерэг нөлөөтэй боловч тогтвортой өсөлтийн орчныг бүрдүүлж чадахгүй байгаа нь алдаатай үзэгдэл юм. Төсвийн орлогын илүүдэл нь нэг талаас эдийн засгийг дэмжих чухал хэрэгсэл ч нөгөө талаас эдийн засаг дахь тэлэх бодлогыг хөөргөдөг сул талтай. Мөн судалгаанд манай улс дан ганц түүхий эдийн үнэ дээр түшиглэсэн эдийн засгийг хөгжүүлж байгаа нь эрсдэлтэй хэмээн үзсэн байна. Монголын санхүүгийн системийн хөгжил эрчимтэй явагдаж байгаа бөгөөд банк давамгайлсан бүтэцтэй байгаа нь санхүүгийн зуучлалыг цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Харин МУИС-ЭЗС, Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн хамтран явуулсан бодлогын судалгааны дүгнэлтээс харахад Төсвийн бодлого нь бизнесийн мөчлөг дагасан шинж чанартай байна гэж удаа дараа тэмдэглэсэн ба улсын төсөв, төсвийн бодлого нь эдийн засгийг тогтворжуулах үүрэг, зорилгоосоо хазайж эдийн засгийн бодлого чанараа алдаж байна гэж дүгнэсэн байна.

Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн хоорондын нөлөөллийг тооцоход зэсийн ханш нь хөрөнгө оруулалтад богино хугацаанд эерэг нөлөөтэй байгаа ч дунд хугацаанд бага зэрэг сөрөг нөлөөтэй, зээлийн хүү нь хөрөнгө оруулалтад сөрөг, Хэрэглээний үнийн индекс нь хөрөнгө оруулалтад нэг улирлын дараа эерэгээр нөлөөлж байгаа бол харин хоёр улирлын дараа сөргөөр нөлөөлнө гэсэн үр дүн гарчээ. Энэ нь ерөнхийдөө зэсийн ханш хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэй байгааг харуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулагч нар нь мөнгөө үнэгүйдлээс хамгаалах зорилгоор бас хөрөнгө оруулалт хийдэг болох нь харагдаж байна. Зээлийн хүү өсөх нь компаниудын зээл авах боломжийг хязгаарладаг учраас хөрөнгө оруулалт нь зээлийн хүүнээс сөргөөр хамаарч байна. Зээлийн хүү 1%-иар буурахад нийт хөрөнгө оруулалт 31370 сая төгрөгөөр нэмэгдэх хандлагатай гэж үзжээ.

4. Хөрөнгө оруулалтын шингээх чадварт институцийн хөгжлийн нөлөөлөл

Институци нь хүмүүсийн хооронд үүсч буй харилцаа, үйлдлийг зохицуулах журмууд ба тэдгээрийг хэрэгжүүлэх орчин, хэрэгслүүд гэж үзэж болно. Шинжлэх ухааны утгаар нь авч үзвэл институци нь хүмүүсийн хоорондох аливаа харилцаа, солилцоог журамласан нийгмийн журмууд бөгөөд:

- албан журмууд /хууль, хуулийн зохицуулалт, эрх зүйн орчин/
- албан бус нийгмийн журмууд /нийгмийн ёс, дэг, уламжлал/
- тэдгээрийн биелэлт, хэрэгжилт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Мөн бизнесийн дүрэм журам, өмчийн эрхийн хамгаалал, авлигал зэргийг институцийн үзүүлэлт болгож авч үзсэн. Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч маш олон дутагдалтай тал, санал шүүмжлэл, эсэргүүцэлтэй тулгарсаар ирсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс Засгийн газраас бодлогын чанартай олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн өөр нэг бүлэг хууль бол Чөлөөт бүсийн тухай, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, Замын-Үүд

эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд юм. Хэдийгээр эдгээр хууль хөрөнгө оруулалтын асуудлыг боломжийн хэмжээнд зохицуулсан боловч төрийн албаны хүнд суртал, гадаад сурталчилгаа, хөрөнгө оруулагчдыг татах бодлого, хөрөнгийн гачигдал, ажлын арга барил, зохион байгуулалтаас шалтгаалж тун хангалтгүй хэрэгжиж байна хэмээн дүгнэсэн байна.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо зах зээлд чиглэсэн (market-seeking), ашигт малтмалд чиглэсэн (resource-seeking), үйлдвэрлэлийн бүтээмжид чиглэсэн (efficiency-seeking), стратегийн нөөц баялаг болон чадварт чиглэсэн (strategic asset or capability-seeking) хөрөнгө оруулалтын алинд нь түлхүү анхаарал тавих, дэмжих, ямар хөнгөлөлт үзүүлэх бодлогыг сайтар тодорхойлох хэрэгтэйг судалгааны баг онцолсон байна.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас дэлхийн 140 орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадварыг үнэлэхэд, Монгол Улс энэ үзүүлэлтээр харьцангуй их хөрөнгө оруулалт татаж чадсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй өндөр чадавхтай орнуудын жагсаалтад[205] багтах болсон байна.

Хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг өргөтгөж, үйлдвэрлэлийг бүтээмжийг дээшлүүлдэг. Манай улсын хувьд харамсалтай нь тийм ч үр өгөөжтэй байдал ажиглагдахгүй байна хэмээн судалгааны төгсгөлд дурдсан байна. 2002-2008 онуудад хөрөнгө оруулалт 69.2% өссөн байхад нийт бүтээмж 62.1%-иар дээшилсэн байна. Манай улсын хөрөнгө оруулалтын ихэнх хувь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж байгаа учраас бүтээмжийг төдийлөн ихээр нэмэгдүүлж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулалт нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих урамшууллын механизм болж эдийн засагт үр өгөөжөө өгч байгаа бодит үр дүн муу байна. Дэд бүтцэд төвлөрсөн хөрөнгө оруулалтыг хийж байгаа нь төдийлөн үр ашгаа өгөхгүй удаашралтай байна. Эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн салбар руу хандсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлөөр сул бүс нутагт оюуны хөрөнгө оруулалтыг түлхүү хийх тал дээр анхаарах хэрэгтэй гэсэн санал зөвлөмжүүдийг тусгасан байна. Тус судалгааны эдийн засгийн шинжилгээ, тооцооллын үндсэн дээр гарсан гол дүгнэлтүүдээс дурдвал:

Хөрөнгө оруулалт болон ДНБ-ий хугацаа хоорондын хамаарлаас харахад хөрөнгө оруулалт ерөнхийдөө хугацааны 1 үеийн хожимдолтойгоор үр ашгаа өгдөг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл энэ жил хийгдсэн хөрөнгө оруулалт дараа жилийн ДНБ-ий өсөлтөд чухал нөлөөтэй гэсэн үг. Хөрөнгө оруулалтын үр ашгийг хэмждэг нэг үзүүлэлт болох ICOR[206] коэффицент буурах хандлагатай байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг өсч байгааг харуулж байна.

Хэсгийн корреляцийн шинжилгээнээс харахад ДНБ-ий 22% нь хөрөнгө оруулалтын оролцоотой бий болж байна. Үүнээс хувийн хөрөнгө оруулалт нь 14%, улсын хөрөнгө оруулалт нь 8% орчмыг нь бий болгож байна. Хувийн хөрөнгө оруулалт нь улсын хөрөнгө оруулалтаас 1.75 дахин өндөр үр ашигтай байна.

ДНБ нь хөрөнгө оруулалтанд эерэг нөлөөтэй байна. ДНБ 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд дараагийн улиралд нь хөрөнгө оруулалт 1.24 сая төгрөгөөр нэмэгдэх хандлагатай байна.

[205] http://www.investmongolia.com/forum/speech/1stday/FIFTA%20Chairman_B.Ganzorig-mon.pdf
[206] Incremential capital output rate

Татварын орлого нь хөрөнгө оруулалтад сөрөг хамаарч байна. Онолын хувьд татварын орлого нь хөрөнгө оруулалтад эерэг эсвэл сөрөг нөлөөтэй эсэх нь маргаантай байдаг. Учир нь татварын орлого нь төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг гэдэг утгаараа төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар нийт хөрөнгө оруулалтад эерэг нөлөө үзүүлдэг. Гэвч аж ахуйн нэгж, компаниудын ашгийг бууруулдаг учраас компаниудын өөрийн хөрөнгө оруулалтыг бууруулдаг. Энэ талаасаа бол татварын орлого нь нийт хөрөнгө оруулалтад сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Эцэст нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж, доорх асуудлуудыг онцолж байна. Үүнд:

1. Манай улсын хувьд хөрөнгө оруулалт ерөнхийдөө хугацааны 1 үеийн хоцрогдолтойгоор үр ашгаа өгдөг байна. Өөрөөр хэлбэл энэ жил хийгдсэн хөрөнгө оруулалт дараа жилийн ДНБ-ий өсөлтөд нөлөөлнө гэсэн үг юм.
2. Манай санхүүгийн тогтолцоонд банкны салбар давамгайлж байгааг өөрчилж санхүүгийн зуучлалыг цаашид хөгжүүлэх шаардлагатай.
3. Монгол Банкнаас явуулж буй мөнгөний хатуу бодлого нь зөвхөн зээлийн хүүг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг бууруулах байдлаар илэрч буй болохоос биш эдийн засгийг хөргөхөд үзүүлэх нөлөө нь бага байна.
4. Манайд ДНБ-ий өсөлтийн 22%-ийг хөрөнгө оруулалтаас хангаж байгаа бол үүний 14%-ийг хувийн, үлдсэн 8%-ийг улсын хөрөнгө оруулалт эзэлж байна. Нийт хөрөнгө оруулалтын 6.5% эзэлдэг аж ахуйн нэгжийн хувийн хөрөнгө оруулалт нь улсын хөрөнгө оруулалтаас даруй 1.75 дахин өндөр үр ашигтай байна.
5. Хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг өргөтгөж, бүтээмжийг дээшлүүлдэг. Манай улсын хувьд харамсалтай нь тийм үр өгөөжтэй байдал ажиглагдахгүй байна.
6. Манай улсын хөрөнгө оруулалтын ихэнх хувь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж байгаа учраас бүтээмжийг төдийлөн ихээр нэмэгдүүлж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл болон техникийн даалгавар боловсруулах чадавх сул, олон улсын гэрээний эрх зүйгээр мэргэшсэн хүний нөөц дутагдаж байна.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаарх гадаад дотоодын онол, арга зүйн судалгааны мэдээлэл, материалыг /гадаад хэл дээр байж болно/ файлаар болон хэвлэмэл байдлаар ирүүлнэ үү гэсэн захиалагчийн хүсэлтийн дагуу доор дурдсан мэдээ мэдээлэл, судалгааны ажлуудыг хүргүүлж байна. Үүнд:

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээрх материал:

1. Т.Ганчимэг, 2009 он, “Макро эдийн засгийн хөрөнгө оруулалтын үр ашгийг хэмжих нь”
2. Т.Дорж, 2008 он, “Хөрөнгө оруулалтын шингээх чадвар” судалгаа
3. Соёмбо баг, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, 2011 он, “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа” БС-02
4. Гантулга, ERI (Эдийн засгийн судалгааны хүрээлэн), 2012 он, ”Монгол Улсын уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлж буй үр ашгийг дээшлүүлэх зарим арга”

Гадаад хэл дээрх материал:

5. Cohen, W.M. and D.A. Levinthal (1990), Absorptive capacity: A new perspective on learning and innovation., Administrative Science Quarterly
6. Signe Krogstrup, Linda Matar, 2005, Foreign Direct Investment, Absorptive Capacity and Growth in the Arab World
7. Borensztein, E, De Gregorio, J, and Lee, J-W. 1998: How Does Foreign Direct Investment Affect Economic Growth Journal of International Economics.
8. H. Nguyen G. Duysters J. Patterson H. Sander “Foreign Direct Investment Absorptive Capacity Theory’’
9. Li, Xiaoying and Xiaming Liu, 2005, Foreign Direct Investment and Economic Growth: An Increasingly Endogenous Relationship, World Development, forthcoming.
10. UNCTAD, 2004, World Investment Report 2004: The Shift Towards Services. York and Geneva: UN.
11. Sourafel Girma, Holger Gorg, 2005, Foreign direct investment, spillovers and absorptive capacity: evidence from quantile regressions
12. Beatrice Farkas, 2012, Absorptive capacity and impact of the PDI on economic growth
13. Davide castellani ise-universita di urbino, 2002, Technology gaps, absorptive capacity and the impact of inward investments on productivity of european firms
14. CEIOPS’ Advice for Level 2 Implementing Measures on Sollvency SCR standard formula Loss-absorbing capacity of technical provisions and deferred taxes, 2009
15. Xiaolan fu, 2008, Foreign direct investment, Absorptive capacity and regional innovation capabilities: Evidence from China
16. United nations development programme, 2007, Asian foreign direct Investment in Africa
17. Yuko Kinishita and Chia-Hui Lu, 2006, On the Role of Absorptive Capacity: FDI Matters to Growth
18. Isabel Blvarez and Raquel Marin, FDI and world heterogenities: The role of absorptive capacities Thomas Farole and Deborah Winkler, Policy Research Working Paper, 2012, Foreign Firm Characteristics, Absorptive Capacity and the Institutional Framework, The Role of Mediating Factors for FDI Spillovers in Low-and Middle-Income Countries